

БАТЛАВ.  
САЙХАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.МӨНХБОЛД

САЙХАН СУМЫН ЗДТГ, УУЛ УУРХАЙН ААНБ-ЫН  
ХООРОНД БАЙГУУЛСАН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2021.11.17

Сайхан сум

**Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийг үндэслэн энэхүү гэрээг:

Нэг талаас Сэлэнгэ аймаг Сайхан сумын "Засаг даргын Тамгын газар" гэх /төлөөлж/ Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн Б.Хэрлэнтунгалаг нөгөө талаас "Бижбугат" ХХК-ийг төлөөлж захирал албан тушаалтай Э.Сайнзаяа нар нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.3 "б", 29.1.3 "е", 29.1.3 "н" дэх заалтуудыг тус тус үндэслэн дор дурьдсан нөхцөлүүдийг хэлэлцэн тохиролцож энэхүү Нийгмийн хариуцлагын гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г байгуулав.

**Нэг. Гэрээний зорилго**

Сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААНБ, ЗДТГ-ын хоорондын хамтын ажиллагааг сумын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх тогтвортой бичил уурхайг хөгжүүлэхэд оршино.

**Хоёр. Уул уурхайн аж, ахуй нэгж байгууллагын хүлээх үүрэг**

2.1. Сайхан сумын Номгон тосгон, Овоот, Дөмбөн, Жимстэй хорооллын автозамыг сайжруулах хатуу хучилттай болгох бүтээн байгуулалтын ажилд 10,000,000 /арван сая/ төгрөгтэй дүйцэх хэмжээний ажил үйлчилгээ үзүүлнэ.

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зохих хууль тогтоомжийн дагуу уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн газарт амьдарч байгаа иргэдийн аюулгүй байдал хангах

2.4. Орон нутгийн 5-10 иргэнийг ажлын байраар хангах

2.5. Уул уурхайн ил тод байдлыг хангах

2.6. Сайхан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид сар бүр тухайн орд газрынхаа нөөц болон олборлолт явуулсан мэдээ тайланг ирүүлж байх

2.7. Эвдрэлд орсон газрын байгаль орчныг нөхөн сэргээх, мод, бут, сөөг, олон наст ургамал тарих

**Гурав. Засаг даргын Тамгын газрын хүлээх үүрэг**

3.1. Сумын нутаг дэвсгэр дээр хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлнэ.

3.2. Тусгай зөвшөөрөлтэй ААНБ-д үндсэн үйлдвэрлэлээс гадна бусад ажил үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлнэ.

3.4. Сумаас уурхайн үйл ажиллагаатай танилцаж мэдээлэл солилцоно.

#### **Дөрөв. Хамтран хэрэгжүүлэх ажлын чиглэлүүд**

4.2. Суманд хэрэгжих томоохон төсөл /орон сууц, зам гүүр, дэд бүтэц гэх мэт/ хэрэгжүүлэхэд хамтран оролцох

4.3. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хамтран ажиллах

4.5. Уул уурхайн сургалт, дадлага хийхэд хамтран ажиллана

#### **Тав. Бусад болон Хариуцлага**

5.1. Хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй улсын байцаагчийн тавьсан шаардлагыг үл хүндэтгэсэн тохиолдолд ААНБ-ын тусгай зөвшөөрлийг холбогдох газарт уламжилж цуцлах хүртэл арга хэмжээ авах болно.

5.2. Энэхүү гэрээг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаагаар байгуулав.

5.3. Дээрхи гэрээг жил бүр тогтмол дүгнэж байх бөгөөд гэрээний аль нэг тал үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн нь гэрээг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН:

БИЖБУГАТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ:



Б.ХЭРЛЭНТУНГАЛАГ

Э.САЙНЗАЯА